

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 5/03

Мандалговь

О.Ганцэцэгийг эрх бүхий албан тушаалтнаар
томилох тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Нийт албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх заалт, Авлигатай тэмцэх газрын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар Захиргаа аж ахуйн албаны Дотоод аудит хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн О.Ганцэцэгийг 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн томилсугай.


2. О.Ганцэцэгт Эрх бүхий албан тушаалтны албан үүргийг гүйцэтгэсний цалингийн нэмэгдэлийг үндсэн цалингийн 10 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Энхдөл)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг О.Ганцэцэгт үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ



481200553